## ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

# НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2025 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН 22-НЫ ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2025 оны 09 дүгээр сарын 30 — Улаанбаатар хот

| Д\д | Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа | Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан | Цаашид авч хэрэгжүүлэх арга зам | Хувь |
|---|---|---|---|---|
| **Үүрэг даалгавар НЭГ.** Улс, нийслэлийн төсөв, гадаадын зээл, тусламж, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтаар хийгдэж байгаа бүх салбарын ажлуудаа эрчимжүүлэх. | | | | |
| 1 | Дүүрэгт 2025 онд хэрэгжиж байгаа улс, нийслэл, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сан, дүүрэг, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар.<br>- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаа 2024-2025 онд он дамжин хэрэгжиж байгаа нийт 17 төсөл, арга хэмжээ<br>- Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд шинээр хэрэгжих 5 төсөл, арга хэмжээ, 2024-2025 онд он дамжин хэрэгжиж байгаа нийт 10 төсөл арга хэмжээ<br>- Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024-2025 онд хэрэгжих 3 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна.<br>Улс, нийслэл, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны төсвийн хөрөнгө оруулалтын нийт 35 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаагаас:<br>• Бүрэн хэрэгжиж дууссан -7<br>• 2025 онд хэрэгжиж дуусах -10<br>• Гэрээ байгуулагдан хэрэгжиж байгаа -14<br>• Газар чөлөөлөлтийн шатандаа -2<br>• Гэрээ цуцлагдсан -2 төсөл арга хэмжээ байна.<br>Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэж байгаа байгууллагуудад 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр 2025 онд багтаан ажлаа эрчимжүүлж дуусгах талаар чиглэл өгч ажилласан. | | | 70% |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн жишиг “Эрүүл мэндийн төв”-ийг ашиглалтад оруулах ажлын хүрээнд “Дүүргийн нэгдсэн эмнэлгийн бие даасан эх үүсвэр” барих барилгын ажлын нөлөөлөлд өртсөн 17 иргэнтэй зөвшилцөн дүүргийн Засаг даргын “Нөхөх олговор олгох тухай” захирамж гарч дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар газрыг чөлөөлөн ажиллаж байна. | | | |
| **Үүрэг даалгавар ХОЁР.** Захиалагчийн хяналт тавьж буй байгууллагууд хөрөнгө оруулалтын ажлын чанар, стандартын хяналтыг сайжруулах. | | | | |
| 2 | Чингэлтэй дүүргийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ-аас 2025 онд хэрэгжих дүүрэг, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын нийт 40 ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байна. Үүнээс:<br>• 21 ажлыг комисст хүлээлгэн өгч, санхүүжилт олгосон<br>• 13 ажил хэвийн үргэлжилж байна. | | | 70% |
| **Үүрэг даалгавар ГУРАВ.** Төсвийн орлого бүрдүүлэх ажлыг бүх шатанд эрчимжүүлж, төсвийн орлогын ногдол төлөлтийг бүрэн хийх. | | | | |
| 3 | 2025 оны 09 дүгээр сарын 24-ний байдлаар өссөн дүнгээр:<br>• Улсын төсөвт 84,511,447.11 мянган төгрөг төвлөрүүлэхээс 77,647,050.50 мянган төгрөг төвлөрүүлж 91.88%,<br>• Нийслэлийн төсөвт 17,413,242.83 мянган төгрөг төвлөрүүлэхээс 14,242,156,20 мянган төгрөг төвлөрүүлж 81.79%,<br>• Дүүргийн төсөвт 221,344,470.70 мянган төгрөг төвлөрүүлэхээс 189,077,104.33 мянган төгөрөг төвлөрүүлж 85.42%-ийн биелэлттэй байна. | | | 90% |
| **Үүрэг даалгавар ДӨРӨВ.** Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн дагуу төсвийн зардлын хэмнэлтийг хэрэгжүүлэн, төсвийн сахилга бат, дотоод хяналтыг сайжруулах. | | | | |
| 4 | Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журам”-ын дагуу батлагдсан төсвийн хүрээнд төсөл арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр ашигтайгаар хэрэгжүүлэн нийт 78 байгууллагын бүлэг хоорондын болон сар хоорондын | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | төсөвт зохицуулалт хийх тухай саналыг судлан, төсвийн зардлын хэмнэлтийг хэрэгжүүлж, төсвийн жилд өр авлага үүсгэлгүй, зориулалт дагуу зарцуулж, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулахад анхааран ажиллаж байна.<br>Жилийн төсвийг бодитой, тодорхой зорилтууд, хэрэгцээтэй төслүүдийн дагуу дахин төлөвлөж Дүүргийн батлагдсан төсөвт тодотгол оруулахаар ажиллаж байна. Батлагдсан төсвийг үр ашигтай, зөв зарцуулахад Монгол Улсын Төсвийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам, холбогдох Сангийн сайдын тушаал, бусад холбогдох журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.<br>Хийгдсэн ажлууд:<br>- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн “Дүүргийн 2025 оны төсөв батлах тухай” 14 дүгээр тогтоолоор төсөв батлагдсан.<br>- Дүүргийн Засаг Даргын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн “Төсвийн хуваарь батлах тухай” А/13 дугаар захирамжаар хуваарь батлагдсан.<br>- Дүүргийн Засаг Даргын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” А/102 дугаар захирамжаар хуваарийг өөрчлөн баталсан. | | | 90% |
| **Үүрэг даалгавар ТАВ.**<br>Ухсан нүх, эвдэрч гэмтсэн авто зам, явган зам, талбайг нөхөн сэргээх, засварлах ажлаа чанартай гүйцэтгэж, хэрэгжилтэд хяналт шалгалт хийх. | | | | |
| 5 | Дүүргийн нутаг дэвсгэр дэх шугам сүлжээний засвар шинэчлэлтийн ажлын дараах нөхөн сэргээлтэд хяналт тавьж, хариуцсан байгууллагуудад албан бичиг хүргүүлэн ажиллаж байна.<br>Тус ажлын хүрээнд дүүргийн 1 дүгээр хороо, 1, 3, 12, 13, 14 дүгээр байрны цахилгаан хангамжийн тэжээлийн кабель шинэчлэх ажил гүйцэтгэсний дараах нийтийн эзэмшлийн болон сургуулийн өмнөх боловсролын 33 дугаар цэцэрлэгийн ногоон байгууламж, авто зам, явган хүний замын нөхөн сэргээлтийг холбогдох стандарт, норм дүрмийн дагуу хийж гүйцэтгүүлэх тухай 03/2668 тоот албан бичгийг Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-д хүргүүлэн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгүүлэн ажилласан.<br>Мөн ОСНААУГ-с хийж гүйцэтгэсэн шугам сүлжээний засвар шинэчлэлтийн ажлын нөхөн сэргээлтийг 2 байршилд хийж гүйцэтгүүлээд байна. | | | 50% |

<table>
<tr><td></td><td>


</td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td colspan="5">Үүрэг даалгавар ЗУРГАА. Нийслэлийн хэмжээнд гэрэлтүүлгийн асалтад хяналт тавьж, хариуцлагагүй ажилласан аж ахуйн нэгж, байгууллагын гэрээг цуцлах.</td></tr>
<tr><td>6</td><td>“Макс Волтеж" ХХК, "Энержи комплекс "ХХК, "Спэйшлтим ап" ХХК-иудын гэрэлтүүлгийн асалт дунджаар 83,3 хувьтай байгаа тул дээрх байгууллагуудад хариуцсан байршлуудынхаа гэрэлтүүлгийн засвар арчлалт, иргэдийн өргөдөл гомдлыг хурдан шуурхай шийдвэрлэх тухай 03/2740, 03/2741, 03/2742 тоот албан бичгүүдийг хүргүүлээд байна.<br> <br>2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн 3 байгууллагын гэрэлтүүлгийн асалтад үзлэг, шалгалт хийхээр төлөвлөн ажиллаж байна.</td><td></td><td></td><td>70%</td></tr>
<tr><td colspan="5">Үүрэг даалгавар ДОЛОО. Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, “Хотула” аппликейшний үйл ажиллагаа болон картны хэрэглээг жигдрүүлж, сайжруулсан түлшний талаарх мэдээллийг бэлтгэж, танилцуулах.</td></tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| 7 | Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх болон түлшний хүртээмж хангамжийг сайжруулах, иргэдэд Хотула аппликейшний үйл ажиллагаа болон картны асуудлаар мэдээлэл өгөх зорилгоор 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр 14 цагаас дүүргийн 7-24 дүгээр хороодын Засаг дарга нар болон холбогдох бусад мэргэжилтнүүдэд Таван толгой түлш ХХК-ийн Борлуулалтын албаны дарга О.Мишээл, Борлуулалтын албаны Чингэлтэй дүүргийг хариуцсан мэргэжилтэн Б.Төгөлдөр, Хийн түлшний инженер Б.Батбилэг, “Дижитал ИнфоСек” ХХК гүйцэтгэх захирал Ч.Алтан-Очир нар ирж мэдээлэл өгсөн.<br>Мөн 7-24 дүгээр хороодын нийт зохион байгуулагчид, хэсгийн ахлагч нар 300 орчим мэргэжилтнүүдэд 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр 15 цагаас Нийслэлийн Онцгой байдлын газрын хурлын танхимд сургалт хийж, мэдээлэл өгсөн.<br>  | | | 100% |
| **Үүрэг даалгавар НАЙМ.** 2026 онд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлуудын талаар Дүүргүүдийн Засаг дарга нартай уулзалт зохион байгуулах. | | | | |
| 8 | Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй. | | | - |
| **Үүрэг даалгавар ЕС.** Явган замын засвар, шинэчлэлийн ажлыг эрчимжүүлэх. | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 9 | Дүүргийн 5 дугаар хороо, Их тойруу гудамжны хойд хэсэг Баянбүрдийн тойргоос Гэсэр сүм хүртэлх явган хүний замын засвар шинэчлэлтийн ажлыг “Төрөлх мөрөн” ХХК, Бага тойруу гудамжны хойд хэсэг Анкарагийн гудамжны явган хүний замын засвар шинэчлэлтийн ажлыг “Сантбаян бэрх” ХХК тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.<br>Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд явган хүний зам засвар шинэчлэлтийн ажлыг стандартын дагуу яаралтай хийж гүйцэтгэн байнгын ашиглалтад оруулах тухай 03/2528, 03/2556 тоот албан бичгийг дээрх байгууллагуудад тус тус хүргүүлж, явцын хяналтыг тогтмол тавин ажиллаж байна.<br>Мөн Чингэлтэй дүүргийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төвийн хийж гүйцэтгэж байгаа 3 дугаар хороо, Улсын их дэлгүүрийн арын явган хүний зам болон 2, 5 дугаар хороо, Баруун 4 замаас Баянбүрдийн тойрог хүртэлх байгалийн чулуун явган хүний зам, дүүргийн гэр хорооллын дунд хийгдэж буй явган хүний замын байршлуудад газар дээр ажиллаж, 09 дүгээр сард багтаан ажлыг бүрэн дуусгах чиглэл өгч ажилласан.<br>  | | | 70% |
| **Үүрэг даалгавар АРАВ.** 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдөр хот нийтийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудтай уулзах уулзалтыг зохион байгуулах. | | | | |
| 10 | 2025 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн хот нийтийн аж ахуйн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагуудтай уулзах уулзалтад дүүргийн менежер, хотын стандарт, тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга, ногоон байгууламжийн 3 компани, хог хаягдал, зам талбайн цэвэрлэгээний 2 компани оролцож мэдээлэл авсан. | | | 100% |

<table>
<tr><td colspan="5">Үүрэг даалгавар АРАВ НЭГ. Дүүргүүд нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлыг цэвэрлэх тээвэрлэх ажлыг шуурхай зохион байгуулах</td></tr>
<tr><td>11</td><td>Дүүргүүд нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлыг цэвэрлэх тээвэрлэх ажлыг шуурхай зохион байгуулан ажиллаж байна.<br>Үүнд: Найши трейд ХХК нь 17, 18, 19, 23, 24 дүгээр хороо хариуцсан хороодын айл өрх, ААНБайгууллагын хог хаягдлыг сард 3 удаагийн давтамжтай, хороодын нийтийн эзэмшлийн зам талбайд үссэн үүсмэл хог хаягдал мөн Зуслангийн бүсийн ачаалал ихтэй нэгдсэн хогийн цэгийн хог хаягдлыг өдөрт 3-4 удаагийн давтамжтайгаар шуурхай ачиж тээвэрлэн ажиллаж байна.<br>Чингэлтэй тохижилт үйлчилгээ ХХК нь төвийн 1-16 дугаар хороод, 20, 21, 22 дугаар хороо, дугаар хороонд хог тээвэрлэлтийн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна. Шөнийн хог тээвэрлэлтийг тогтмол зохион байгуулж, тээвэрлэлтийн давтамжийг нэмэгдүүлэх, барилгын болон оврын хэмжээ ихтэй, зам цэвэрлэгээнээс гарсан хог хаягдлыг тухай бүрд нь ачиж, тээвэрлэх, хогны байцаагч нар өдөр бүр хяналт тавьж, аж ахуйн нэгж байгууллагуудтай хог хаягдлын гэрээг тухай бүрд нь байгуулах/ мэдээлэх, ил задгай хог хаяж буй иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад шаардлага тавьж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах, 24 ширхэг ухаалаг хогийн савны угаалга, халдваргүйжүүлэлт, ашиглалт, арчилгааг тогтмол хийх, иргэд болон аж ахуйн нэгж байгууллагуудад ухаалаг хогийн савны зөв хэрэглээ, ач холбогдлыг сурталчлан таниулах чиглэлд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.<br>Хог тээвэрлэлт сард дунджаар 2800-2900 рейс, хог хаягдал 21000-22000 тонн хог хаягдал тээвэрлэж ажиллаж байна.<br><br><br><br></td><td></td><td></td><td>100%</td></tr>
</table>

<table>
<tr><td colspan="5">Үүрэг даалгавар АРАВ ХОЁР. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1084 дүгээр захирамжийн хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах.</td></tr>
<tr><td>12</td><td>Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1084 дүгээр захирамжийн хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд нийт 7-24 дүгээр хороодын айл өрхүүдээр зуух, яндангийн бүрэн бүтэн байдалд хяналт шалгалт хийж ажиллалаа. Үүнд:<br>Нийт 12026 айл өрхийн 10499 зуух, яндaнд шалгалт хийсэн. Үүнээс 9508 зуух, 9780 яндан хэвийн, 951 зуух, 688 яндан эвдрэлтэй байсныг илрүүлж, засаж солих тухай анхааруулга өгч ажилласан. Мөн угаарын хийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өвөлжилтийн бэлтгэл хангах чиглэлээр анхааруулга, сэрэмжлүүлэг, постер мэдээллийг дүүргийн веб сайт, фэйсбүүк групп, хороодын групп, хэсгийн мессенжер групп зэрэг цахим хаягаар сурталчилгааг хийхээс гадна айл өрхөөр орж сурталчилгаа сэрэмжлүүлэг хуудсыг өгч, гарын үсэг зуруулан сэрэмжлүүлэн ажиллаж байна.<br>Дүүргийн хэмжээнд дулаалгын дэвшилтэт технологи, хийн зуух, түлшний хэрэглээ, сэргээгдэх эрчим хүчний мэдээлэл зэргийг танилцуулах зорилгоор Тусгаар тогтнолын талбайд 2025 оны 09 дүгээр сарын 19, 20-ны өдрүүдэд “Дулаалга- Цэвэр агаар” өдөрлөгийг зохион байгуулж, иргэдэд мэдээ мэдээлэл өгч, танилцуулга хийж ажилласан.<br>Дулаанбаатар аяны хүрээнд дүүргийн 7-24 дүгээр хороодын нийт 500 орчим иргэдэд 09 дүгээр сарын 20, 27, 10 дугаар сарын 3, 10-ны өдрүүдэд 4 удаагийн уулзалтыг зохион байгуулж, дулаан алдагдлын үндэс, дулаалгын технологи, ногоон стандарт, аюулгүй ажиллагаа зэрэг мэдээллийг өгч ажиллаж байна.<br> </td><td></td><td></td><td>100%</td></tr>
</table>

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | | | |
| Дундаж үнэлгээ | | | 85% | |

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА Н.МАНДУУЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ж.ТАМИР

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА М.НАВЧАА

БИЕЛЭЛТ НЭГТГЭСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ОТГОНТӨГС